

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

№ 01

Улаанбаатар
хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн
дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалт болон 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Монос хүнс ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ГАНТУЛГА



**Монос Хүнс ХК-ийн 2021 оны санхүү, үйл ажиллагааны тайланд
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас өгсөн дүгнэлт**

Монос Хүнс ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгөх дүгнэлт, 2021 оны зорилтуудын биелэлтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Монос Хүнс ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2019 оны 6 дугаар сард сонгогдож, компанийг удирдах үйл ажиллагаандаа сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон ажиллаа. Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхээр зорин ажилласан.

Монос Хүнс ХК-ийн 2021 оны хамгийн том зорилт нь Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрээс гарах бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлж зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх, цар тахлын хүнд нөхцөлд санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн эрсдлийн болон санхүүгийн удирдлагыг хэрэгжүүллээ.

2021 онд бид үйл ажиллагаандаа олон улсын стандартуудыг хэвшүүлж ажиллахаас гадна зах зээлд 13 нэр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж нийт 18.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Хил гаалийн тодорхойгүй байдал, Тээвэр ложистик болон түүхий эдийн үнийн өсөлт, Гадаад валютын ханшийн өөрчлөлт өндөр байсан хэдий ч стратегийн оновчтой шийдвэр гаргалтуудын үр дүнд тавьсан зорилтууддаа амжилттайгаар биелүүлсэн байна.

Монос Хүнс ХК нь цаашдын ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаандаа дараах чиглэлийг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс үзэж байна. Үүнд:

- Шингэн хүнсний үйлдвэрийн өргөтгөл болох MFC 2.0 төслийг эхлүүлж 2023 онд үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Тээврийн үнийн өсөлт болон түүхий эдийн тасалдалд дүн шинжилгээ хийж, эрсдлийг тооцож ашигт ажиллагааг хангаж ажиллахад онцгой анхаарах
- Хувьцааны ханшийн өсөлт, тогтвортой байдлыг дэмжсэн компанийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах Пи Ар, маркетингийн ажлыг чанаржуулах зэрэг болно.

Цар тахлын нөлөөллөөр Монгол улсын эдийн засаг 1.4% болж буурсан хүнд нөхцөлд Монос хүнс ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын багийн хамт олон төлөвлөсөн зорилтдоо хүрэхийн тулд бүхий л нөөц бололцоогоо бүрэн дайчлан ажиллаж 2020 онтой харьцуулахад борлуулалтаар 51%, цэвэр ашгаар 101% өсөлттэй ажилласан тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс “маш сайн” ажилласан хэмээн дүгнэж байна.

“Монос Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

№ 02

Улаанбаатар
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг болон хурлын үйл ажиллагаанд шаардагдах 2022 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсөвт хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулал хорооны даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ГАНТУЛГА

2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ХЭЭХ-ын
ТООТ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ №01



МОНОС ХҮНС ХК ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

	/мянган төгрөг/
1. ТУЗ-ийн хурлын зардал	8,000
• ТУЗ-ийн ээлжит хурал	4,000
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	4,000
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ	56,500
• ТУЗ-ийн ээлжит хурал	44,500
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	12,000
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал	25,000
НИЙТ ДҮН	89,500

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

№ 23

Улаанбаатар
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
Гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд:
 - 1.1. Л.Хүрэлбаатар
 - 1.2. Х.Ананд
 - 1.3. Ч.Баттогтох
 - 1.4. А.Отгондарь
 - 1.5. Х.Солонго
 - 1.6. Ц.Цэцэгбадам
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд:
 - 2.1. Ш.Алтанбагана
 - 2.2. Б.Гантулга
 - 2.3. О.Лхагвасүрэн нарыг тус тус сонгосугай.
3. Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, “Монос хүнс” ХК-ийн дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн журам” зэрэг засаглалын тогтолцооны холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн мэдээллийг хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хууль журамд заасны дагуу мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Б.ГАНТУЛГА